



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 12 өдөр

Дугаар А/401

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ын “б”, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийн 3.1.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар “Өсөн дэвжих зам” ХХК-ийн хийж гүйцэтгэсэн Нүүдлийн авто замын засвар арчлалт /Ховд/-ын 2-р багц ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Баярсүх	- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга
Гишүүд: Б.Ганзориг	- Мэргэжлийн хяналтын газрын Авто замын хяналтын улсын байцаагч
М.Батхишиг	- Үенч сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга
Э.Уртнасан	- Үенч сумын Засаг дарга
Ч.Ганбат	- Үенч сумын Засаг даргын орлогч
Б.Бурмаа	- Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн
И.Гантогтох	- Ховд аймаг дахь Цагдаагийн газрын ахлах зохицуулагч
Н.Эрхэм	- Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Үенч сум хариуцсан байгаль хамгаалагч
С.Батдорж	- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасгийн дарга
А.Волга	- “Өсөн дэвжих зам” ХХК-ийн захирал

Нарийн бичгийн
дарга: Д.Эрдэнэбат

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хөрөнгө оруулалт, Хөгжлийн бодлого,
төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

2. "Өсөн дэвжих зам" ХХК -ийн хийж гүйцэтгэсэн ажлыг захиалагчаас өгөгдсөн ажлын тоо хэмжээтэй тулган шалгаж, өмч бүртгэлд тусгаж хүлээн авах эсэх талаар шийдвэр гарган танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Баярсүх/-д даалгасугай.

3. Дээрх ажилтай холбогдуулан гарах зардлыг захиалагчийн хяналтын зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/ нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН